МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
http://www.mmhi.gov.mn

2020.10.06 № 01/2481

танай ____________-ны № ____________-т

Тушаал хүргүүлэх тухай

МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 94 дүгээр тушаалаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан.

Уг төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэх нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-246 дугаар тушаалаар батлсныг үүгээр хүргүүллээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь тухай бүр ирүүлж ажиллана уу.

Сайдын тушаалыг хавсаргав.

Хавсралт 7 хуудастай.

Г.ЁНДОН

08 1296

# МОНГОЛ УЛСЫН
# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 02 өдөр Дугаар А-246 Улаанбаатар хот

Төлөвлөгөөний хэрэгжилтийг
хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 32 дугаар Захирамж, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 94 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 94 дүгээр тушаалаар батлагдсан, Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран шуурхай зохион байгуулж, үр дүнг тогтоосон хугацаанд нь тухай бүр танилцуулж ажиллахыг Газрын тосны бодлогын газар /Б.Анхбаяр/, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/ нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т даалгасугай.

САЙД П.ЁНДОН

08 004?

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн
А-246 -р тушаалын хавсралт

**Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 94 дүгээр тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө**

| № | Арга хэмжээ | Үйл ажиллагаа | Хариуцах эзэн | Хамтрах байгууллага | Хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэхээр шалгарсан БНЭУ-ын компанитай гэрээ байгуулж, бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлыг зохион байгуулах. | 1. Технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэхээр шалгарсан БНЭУ-ын компанитай хэлэлцээ хийх. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /УУХҮЯ/-ны Газрын тосны бодлогын газар /ГТБГ/-ын дарга Б.Анхбаяр, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" /МГТБҮ/ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | /-/ | 2020 оны 10 дугаар сар | 1. Хэлэлцээ хийсэн байна. | |
| | | 2.Технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэхээр шалгарсан БНЭУ-ын компанийн төлөөлөгчдийг Монгол Улсад урих, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах. | | /-/ | | 2. Шалгарсан компанийн ажилчдыг Монгол Улсад урьж иргүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. | |
| | | 3. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, батлуулах | | /-/ | | 3. Төлөвлөгөөг боловсруулсан байна. | |
| 2 | Түүхий тос дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг гадаад, дотоод эх үүсвэрээс шийдвэрлэх талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | 1.Төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй санал солилцох цахим уулзалт зохион байгуулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | /-/ | 2020 оны 10 дугаар сар | 1. Цахим уулзалт зохион байгуулсан байна. | |
| | | 2. Тос дамжуулах хоолой санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын баталгаа гаргах замаар шийдвэрлэх талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | Сангийн яам /СЯ/ | 2020 оны 10 дугаар сар | 2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |
| 3 | Монгол Улсын Засгийн газрын гадаад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй тус төслийг төлөвлөсөн хугацаанд багтаан хэрэгжүүлэхтэй холбогдуулан төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зохицуулалтын хүрээнд хууль, тогтоомжийн төсөл боловсруулж Засгийн газар, | 1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | СЯ, Хууль зүй, дотоод хэргийн яам /ХЗДХЯ/ | 2020 оны 11 дүгээр сар | 1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулан СЯ, ХЗДХ-ийн яамдаар хянуулсан байна. | |
| | | 2. Хуулийн төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | Бусад яамд | | 2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Улсын Их Хуралын хуралдаанаар хэлэлцүүлэх. | 3. Хуулийн төслийг УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | /-/ | | 3. Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн байна. | |
| 4 | Төслийн ерөнхий гүйцэтгэгч Энэтхэгийн талын боловсруулсан барилга байгууламжийн төлөвлөлт, зураг төсөл, норм дүрэмтэй холбоотой англи хэл дээрх баримт бичгийг хүлээн авах, батлах ажлыг зохион байгуулах | 1. Үйлдвэрийн бүтээн байгуулалт, барилга угсралт, ашиглалтын үед ашиглах норм, дүрэм, журам, стандартын жагсаалтыг гаргах. | МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | Барилга, хот байгуулалтын яам /БХБЯ/ | 2020-2024 он | 1. Жагсаалт гаргасан байна. | |
| | | 2. Энэтхэгийн талын боловсруулсан барилга байгууламжийн төлөвлөлт, зураг төсөл, норм дүрэмтэй холбоотой англи хэл дээрх баримт бичгийг хүлээн авах талаар Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгах. | | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, | | 2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгасан байна. | |
| 5 | Үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотойгоор олгосон газрыг газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх | 1. Үйлдвэрийн зориулалтаар олгосон газрыг газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгуулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | СЯ, БХБЯ | 2020 оны 10 дугээр сар | Уг асуудлыг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгуулсан байна. | |
| | | 2. Үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотойгоор олгосон газрыг газрын төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, яамдаас санал авах. | | | | Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан байна. | |
| | | 3. Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | |
| 6 | Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцогч ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч талуудыг бүх төрлийн татвар, төлбөр, хураамжаас чөлөөлөх асуудлыг судлан холбогдох тооцоо, судалгааг гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | 1. Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцогч ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч талуудыг бүх төрлийн татвар, төлбөр, хураамжаас чөлөөлөх асуудлыг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | СЯ | 2020 оны 11 дүгээр сар | 1. Уг асуудлыг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгуулсан байна. | |
| | | 2. Үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөх бүх төрлийн татвар, төлбөр, хураамжийн тооцооллыг гаргах. | | | | 2. Холбогдох, тооцоо судалгааг гаргасан байна. | |
| | | 3. Үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөх бүх төрлийн татвар, төлбөр, хураамжийг чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах. | | | | 3. Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан байна. | |
| | | 4. Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | 4. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох гадаадын мэргэжилтэн, инженер, техникийн ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөр болон визний хураамжаас чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | 1. Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох гадаадын мэргэжилтэн, инженер, техникийн ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөр болон визний хураамжаас чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр | ХЗДХЯ, СЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /ХНХЯ/ | 2020 оны 10 дугээр сар | 1. Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан байна. | |
| | | 2. Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр | | | 2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |
| 8 | БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Газрын тос, байгалийн хийн яамтай газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт болон хоёр талын хамтын ажиллагааг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах | 1. Монгол Улсын Гадаад хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Газрын тос, байгалийн хийн яамтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах тухай хүсэлтийг Энэтхэгийн талд тавих. | МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | Гадаад харилцааны яам /ГХЯ/ | 2020 12 дугаар сар | 1. Энэтхэгийн талд хүсэлт тавьсан байна. | |
| | | 2. Хоёр талын Хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулах. | | | | 2. Санамж бичгийн төсөл боловсруулсан байна. | |
| | | 3. БНЭУ-ын Засгийн газартай Хамтран ажиллах тухай санамж бичгийг байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, яамдаас санал аван Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | 3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |
| 9 | Үйлдвэрт шаардлагатай инженер, техникийн болон туслах ажилчдыг сургах, дадлагажуулах чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуулиудад урт, богино хугацааны сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах. | 1. Үйлдвэрт шаардлагатай боловсон хүчнийг сургах урт, богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөрийг боловсруулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, Ашигт малтмал, газрын тосны газар /АМГТГ/-ын дарга Х.Хэрлэн, МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | ГХЯ, Боловсрол, шинжлэх ухаан, спортын яам /БШУСЯ/ | 2020-2024 он | 1. Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. | |
| | | 2. Урт, богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн дагуу гадаад, дотоодын Их, Дээд сургуулиуд болон бусад орны Элчин сайдын яамдад боловсон хүчин сургах, хамтран ажиллах хүсэлт илгээх ажлыг зохион байгуулах. | | | | 2. Гадаад дотоодын Их, Дээд сургууль болон Элчин сайдын яамдад хамтран ажиллах хүсэлт илгээсэн байна. | |
| | | 3. Урт, богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн дагуу үйлдвэрт ажиллах боловсон хүчнийг сонгон шалгаруулах. | | | | 3. Үйлдвэрт ажиллах, сургалтад хамрагдах боловсон хүчнийг сонгон шалгаруулсан байна. | |
| | | 4. Шалгарсан боловсон хүчнийг үе шаттайгаар сургах ажлыг зохион байгуулах. | | | | 4. Үйлдвэр ажиллах тодорхой тооны ажилчдыг сургасан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Газрын тосны хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх | 1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлох. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, АМГТГ-ын дарга Х.Хэрлэн | Бүх шатны Засаг дарга нар | 2020-2024 он | 1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудлаар тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх талаар ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрүүдийг тухай бүр гаргуулсан байна. | |
| | | 2. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. | | | | 2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул чиглэлээр шинээр 4 талбайд БХГ байгуулсан байна. | |
| | | 3. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах. | | | | 3. Газрын тосны хайгуулын Матад-XX, Галба-XI, Хөх нуур-XVIII талбайнуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын тосны нөөцийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | |
| | | 4. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. | | | | 4. Газрын тосны хайгуулын Матад-XX, Галба-XI, Хөх нуур-XVIII талбайнуудын ашиглалтын талбайн асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлнэ. Газрын тосны ашиглалтын Тосон-Уул-XIX, Тамсаг-XXI, БХГ-97 зэрэг ордуудын нөөцийн хөдөлгөөнийг хэлэлцэж, орд ашиглах төлөвлөгөөг шинэчилнэ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Газрын тосны олборлолтыг тогтвортой хадгалах, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, олборлолтыг батлагдсан орд ашиглах төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд хүргэх талаар “Петрочайна Дачин Тамсаг ХХК”-тай хэлэлцэх. | 1. Тосон-Уул XIX, Тамсаг XXI орд газруудын ашиглалт, олборлолтын үйл ажиллагаан дахь Чойбалсангийн ДЦС-аас хамаарч буй цахилгаан, эрчим хүчний хязгаарлагдмал байдлыг шийдвэрлэх. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр | Эрчим хүчний яам /ЭХЯ/ | 2020-2024 он | 1. Чойбалсангийн ДЦС-ын өргөтгөлийн төсөл хэрэгжсэн байна. | |
| | | 2. Дорноговь аймгийн нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн хүрээнд Тосон-Уул, Тамсагийн орд газруудын газрын тосны ашиглалт, олборлолтыг 2012 онд батлагдсан “Орд ашиглах төлөвлөгөө”-нд тусгагдсан хэмжээнд хүргэн нэмэгдүүлэх талаар Гэрээлэгчтэй хэлэлцээр хийх. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, АМГТГ-ын дарга Х.Хэрлэн | /-/ | | 2. Гэрээлэгчтэй хэлэлцээр хийсэн байна. | |
| | | 3. Газрын тосны ашиглалт, олборлолтын тогтвортой ажиллагаа, батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийн орлогын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай тусгай зориулалтын машин техник, тоног төхөөрөмж, бараа материалыг БНХАУ-аас Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомтоор нэвтрүүлэх, Хятад улсын инженер техникийн ажилтан, мэргэжилтнүүдийг Монгол, Хятадын хилийн боомтын “Ногоон гарц”-ыг хэрэгжүүлэх түр журмын дагуу Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомтоор нэвтрүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | /-/ | | 3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |
| 12 | Газрын тос боловсруулах үйлдвэр, газрын тос дамжуулах хоолойн үндсэн, дагалдах байгууламжийн ашиглалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой норм, дүрэм, журам, стандартын төслийг боловсруулж, батлах. | 1. Олон улсад ашиглаж буй Газрын тос боловсруулах үйлдвэр, газрын тос дамжуулах хоолойн барилга байгууламжийн ашиглалт, техник технологи, галын болон хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой норм, дүрэм, журам, стандартын суурь судалгаа хийх. | АМГТГ-ын дарга Х.Хэрлэн | БХБЯ, Стандарт хэмжил зүйн газар /СХЗГ/-ын дарга Б.Билгүүн, | 2020-2024 он | 1. Норм, дүрэм, журам, стандартын суурь судалгааг хийсэн байна. | |
| | | 2. Суурь судалгаанд үндэслэн эрх зүйн баримт бичгийн жагсаалт гаргах, орчуулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, АМГТГ-ын дарга Х.Хэрлэн МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | /-/ | | 2. Жагсаалт гарган, орчуулгыг хийсэн байна. | |
| | | 3. Олон улсад ашиглаж буй норм, дүрэм, журам, стандартын орчуулгад тулгуурлан Үндэсний стандарт, дүрэм, журмын төсөл боловсруулах. | | | | 3. Төсөл боловсруулсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4. Норм, дүрэм, журам, стандартыг батлуулах ажлыг зохион байгуулах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, АМГТГ-ын дарга Х.Хэрлэн МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | СХЗГ-ын дарга Б.Билгүүн, | | 4. Норм, дүрэм, журам, стандартыг батлуулсан байна. | |
| 13 | Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий эдийг тээвэрлэх дамжуулах хоолойн трассыг нарийвчлан тогтоож, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулах. | 1. Дамжуулах хоолойн трассыг нарийвчлан тогтоож, даахцалтай газрыг тодорхойлох. | МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | БХБЯ | 2020 оны 12 дугээр сар | 1. Трассыг нарийвчлан тогтоож, давхцалтай газрын тодорхойлох. | |
| | | 2. Тогтоосон трассын дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоолын төсөл боловсруулах. | | | | 2. Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан байна. | |
| | | 3. Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | 2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |
| 14 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулах. | 1. Үйлдвэрийн ажилчдын хотхоны хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалт болох 95 айлын орон сууцны 3 дугаар блок, 40 айлын орон сууцны 5, 6, 7, 8 дугаар блокуудын барих угсралтын ажлыг эхлүүлэх. | МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | Батлан хамгаалах яам /БХЯ/ | 2021 оны 06 сар | Хотхоны бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна. | |
| | | 2. Объектуудын барилга угсралтын ажлыг БНбД-ээр, зураг төсөл, техникийн нөхцөлийг баримтлан гэрээний үүргийн дагуу хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэн ашиглалтад оруулах | | | 2021 он | Барилгын ажлыг гүйцэтгэж, объектуудыг ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. | |
| 15 | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Бор хөөврийн говийн гүний усны ордоос ашиглах усны хэмжээнд ногдох улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрөөс чөлөөлөх, барилга угсралт бүтээн байгуулалтын үед ашиглах усыг усны төлбөрөөс чөлөөлөх, цаашид газрын тос боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн процессод ашиглах усны дүгнэлтийг гаргах ажлыг зохион байгуулах. | 1. Бор хөөврийн говийн гүний усны ордоос ашиглах усны хэмжээнд ногдох улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрөөс чөлөөлөх, барилга угсралт бүтээн байгуулалтын үед ашиглах усыг усны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгах. | УУХҮЯ-ны ГТБГ-ын дарга Б.Анхбаяр, МГТБҮ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг | Байгаль орчин, аялал жуулчлалын яам /БОАЖЯ/ | 2020 оны 10 дугээр сар | 1. Уг асуудлыг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгуулсан байна. | |
| | | 2. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрөөс чөлөөлөх, барилга угсралт бүтээн байгуулалтын үед ашиглах усыг усны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах. | | | 2020 оны 11 дүгээр сард | 2. Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан байна. | |
| | | 3. Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | 3. Засгийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | |
| | | | | | | | |